

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ



КОМАНДЛАЛЫН ДҮРЭМ

/Албан хэрэгцээнд/

Улаанбаатар хот 2017 он

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал /цаашид командлал гэх/ нь цэргийн захиргааны удирдлагын байгууллага мөн.

1.2 Командлал нь цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагад захирагдана.

1.3 Командлал нь “Батлан хамгаалах бодлогын үндэс”, “Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай”, “Цэргийн албаны тухай”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” Монгол Улсын хууль бусад холбогдох хууль тогтоомж, “Цэргийн нийтлэг дүрмүүд”, “Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм”, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаал, шийдвэр, журам, зааврыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.4 Энэхүү дүрмийг командлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөнө.

Хоёр. Командлалын үйл ажиллагааны зарчим

2.1 Командлал нь үйл ажиллагаандаа “Зэвсэгт хүчний тухай” Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмуудыг мөрдөн ажиллахаас гадна дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- удирдлагын шуурхай байдлыг хангах;
- үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх;
- аюулгүй байдлыг хангах;
- цэргийн хэргийн түүхэн уламжлал, дэвшилтэд арга, технологийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

Гурав. Командлалын үндсэн чиг үүрэг

3.1 Командлал нь дараах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Агаарын цэргийг цэргийн захиргааны нэгдмэл удирдлагаар хангах;

3.1.2 Зэвсэгт хүчний бодлого боловсруулахад оролцох;

3.1.3 Агаарын цэргийг ашиглах үзэл баримтлалыг Зэвсэгт хүчнийг ашиглах үзэл баримтлалтай уялдуулан боловсруулах;

3.1.4 Агаарын цэргийг ашиглах, оперативын дэлгэн байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.5 Агаарын цэргийн анги, салбаруудыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх;

3.1.6 Цэргийн дайчилгааны даалгаврыг боловсруулахад оролцох, биелэлтийг нь хангах арга хэмжээг зохион байгуулах;

3.1.7 Агаарын цэргийн анги, салбаруудын бэлэн байдал, байлдах чадварыг хангах;

3.1.8 Агаарын цэргийн анги, салбаруудын цэргийн албыг зохион байгуулах;

3.1.9 Агаарын цэргийн анги, салбаруудын бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг хангах;

3.1.10 Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагыг агаарын цэргийн талаарх шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

3.1.11 Агаарын цэргийг хөгжүүлэх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах;

3.1.12 Цэргийн удирдлага, холбоо мэдээллийн техник хэрэгслийн шинэчлэлийн бодлогыг тодорхойлоход оролцох, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.13 Агаарын цэргийн сургалт бэлтгэлийн бодлого, стандартыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.14 Төрөл, мэргэжлийн цэргийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бэхжүүлэх;

3.1.15 Агаарын цэргийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах;

3.1.16 Агаарын цэргийг зэвсэглэл, цэргийн техник, бусад материал хэрэгслээр хангах асуудлаар санал боловсруулах;

3.1.17 Агаарын цэргийн анги, салбарын бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

3.1.18 Цэргийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

3.1.19 Агаарын цэргийн хэмжээнд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, хяналт тавих;

3.1.20 Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;

3.1.21 Орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

3.1.22 Хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хүн ам, эд баялгийг аврах, хор уршгийг арилгах бэлтгэлийг хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах.

Дөрөв. Командлалын бүтэц, үйл ажиллагаа

4.1 Командлал нь Зэвсэгт хүчний тухай хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх зорилгод нийцсэн, зэвсэгт хүчний талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлагын, бэлэн байдлын, цэргийн албаны, цэргийн сургалт бэлтгэлийн, ажиллагааны удирдлагын, улсын нисэхийн, агаарын довтолгооноос хамгаалах, материал хангалтын, хүний нөөцийн, санхүүгийн нэгжтэй байна.

4.1.1 Командлалын зохион байгуулалтын бүтэц, орон тоог “Зэвсэгт хүчний тухай” Монгол Улсын хуулийн 7.5-д заасны дагуу Зэвсэгт хүчний жанжин штаб тогтооно;

4.1.2 Командлалыг “Зэвсэгт хүчний тухай” Монгол Улсын хуулийн 11.1.14-д заасны дагуу томилогдсон командлагч удирдана;

4.1.3 Агаарын цэргийн командлагч нь Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын даргад шууд захирагдах бөгөөд Агаарын цэргийн бие бүрэлдэхүүний шууд захирах дарга мөн;

4.1.4 Командлалын удирдлагад Агаарын цэргийн командлагч, штабын дарга, тэргүүн ахлагч нар багтана;

4.1.5 Агаарын цэргийн штабын дарга, тэргүүн ахлагчийн эрх, үүргийг энэхүү дүрмээр тодорхойлно;

4.1.6 Командлалын бие бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг командлагч тогтооно;

4.1.7 Командлалд командлагчийн зөвлөл, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх салбар зөвлөл ажиллана. Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг командлагч батлана;

4.1.8 Командлал нь үйл ажиллагаандаа тэмдэг, баримт бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4.2 Командлал нь агаарын цэргийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэн, анги, салбарын бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэлийг мэргэжлийн удирдлагаар хангах, цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, материал хэрэгслийн хангалтыг зохион байгуулах, хянах, зохицуулах үйл ажиллагааг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.

4.2.1 Агаарын цэргийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэн, анги, салбарын бэлэн байдлыг хангах чиглэлээр:

- агаарын цэргийн байгуулалтын хөгжлийн бодлогыг тодорхойлох;
- агаарын цэргийн хөгжлийн хэтийн болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулах;
- агаарын цэргийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- агаарын цэргийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- агаарын цэргийг ашиглах үзэл баримтлалыг боловсруулж, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаар баталгаажуулах;
- агаарын цэргийг ашиглах үзэл баримтлалд нийцүүлэн төрөл, мэргэжлийн цэргийн дүрэм, журам, зааврыг боловсруулах;
- зэвсэгт хүчнийг ашиглах номлолд тулгуурлан Агаарын цэргийг ашиглах төлөвлөгөөг боловсруулах;
- агаарын цэргийн анги, салбарын байлдааны ажиллагааны болон хариуцлагын бүс, чиглэл, үүргийг тодорхойлох;
- агаарын цэргийн бүтэц, зохион байгуулалт, анги, салбарын байлдааны болон тайван цагийн орон тооны санал боловсруулах;
- агаарын цэргийн анги, салбарын байлдааны болон тайван цагийн үүрэг гүйцэтгэх чадавхийг тодорхойлох, нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

- агаарын цэргийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх;
- улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх үеийн хилийн цэрэгтэй харилцан ажиллах төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх журам боловсруулах, томилгоот бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах;
- аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд юмсыг аврах, хор уршгийг арилгах журам боловсруулах;
- гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- агаарын цэргийн анги, салбарын үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинд хяналт, шалгалт явуулж, үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.2.2 Агаарын цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж, явуулах чиглэлээр:

- цэргийн сургалтын бодлогыг тодорхойлох;
- цэргийн сургалт бэлтгэлийн стандарт, хөтөлбөр, удирдлагын баримт бичгийг боловсруулах;
- цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулж, явуулах;
- энхийг дэмжих болон бусад ажиллагаанд оролцох командлалын анги, салбар, бие бүрэлдэхүүний бэлтгэлийг хангах;
- гадаад орны агаарын бусад төрлийн цэрэгтэй хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулж, явуулах;
- дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт, давтан сургалтанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- анги, салбарын сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх;
- агаарын цэргийн анги, салбарыг ашиглах судалгаа, шинжилгээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах;
- командлалын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах;
- цэргийн сургалт бэлтгэлийн үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх;

4.2.3 Цэргийн албаны зохион байгуулалт, сахилга, дэг журмыг бэхжүүлэх чиглэлээр:

- Монгол Улсын хууль, тогтоомж, Зэвсэгт хүчинд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврын санал боловсруулах,
- агаарын цэргийн анги, салбарт “Цэргийн нийтлэг дүрмүүд”, ЗХЖШ-ын дарга болон командлагчийн тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- анги, салбарын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг захиргааны удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;
- цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;

- агаарын цэргийн бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах ажлыг зохион байгуулах;

4.2.4 Агаарын цэргийн ар талын материал хэрэгсэл, зэвсэглэл, цэргийн техникийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, санхүүгийн хангалтыг зохион байгуулах чиглэлээр:

- зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, материал хэрэгслээр хангах санал, хөтөлбөр, төсөл боловсруулах;
- цэргийн нөөцийн байршил, материал хэрэгслийн төрөл, тоо, хэмжээг тогтоох санал боловсруулах;
- зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, хадгалалт, засвар үйлчилгээ, материал хэрэгслийн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах;
- агаарын цэргийн анги, салбарт цэргийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх;
- цэргийн анги, салбарын хотхоны стандартыг хангахад дэмжлэг үзүүлэх;
- туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- анги, салбарын жилийн төсвийн төслийг боловсруулах, хуваарилах, санхүүгийн хангалтыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- үндсэн болон эргэлтийн хөрөнгийг шинээр авах, шилжүүлэх, данснаас хасах, устгах саналыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

4.3 Командлал нь үйл ажиллагааныхаа тайланг ЗХЖШ-т тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Тав. Агаарын цэргийн командлалын удирдлагын эрх, үүрэг

5.1 Агаарын цэргийн командлагч нь “Зэвсэгт хүчний тухай” Монгол Улсын хуулийн 3 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 16.1.1-16.1.8 заагдсан бүрэн эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

5.1.1 Агаарын цэрэгтэй холбогдох асуудлаар Монгол Улсын хууль тогтоомж бусад удирдлагын баримт бичгийн төсөлд санал оруулах;

5.1.2 Чиг үүргийнхээ хүрээнд тушаал гаргах, удирдамж, албан даалгавар хүргүүлэх;

5.1.3 Агаарын цэргийн командлал болон анги, салбарын удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.4 Агаарын цэргийн офицер, ахлагч нарыг албан тушаалд томилох, чөлөөлөх, цэргийн цол олгох;

5.1.5 Бие бүрэлдэхүүнийг төрийн одон, медаль болон салбарын шагналаар шагнуулах, сургууль, дамжаанд суралцуулах саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

5.1.6 Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, ЗХЖШ-ын даргын зөвшөөрлөөр гадаад орны цэргийн командлал, штабтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

5.1.7 Өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар ЗХЖШ-ын даргад уламжлан төрийн цэргийн байгууллага, аймаг, нийслэлийн цэргийн штабаас шаардлагатай мэдээ, мэдээлэл авах;

5.1.8 Агаарын цэргийн анги, салбарыг аж ахуйн ажилд оролцуулах саналыг ЗХЖШ-ын даргад танилцуулж, шийдвэрлүүлэх;

5.1.9 Цэргийн нийтлэг дүрмүүдэд заагдсан бусад эрхийг тус тус эдэлнэ.

5.2 Агаарын цэргийн командлагч нь тайван цагт дараах үүрэгтэй.

5.2.1 Агаарын цэргийн анги, салбаруудыг захиргааны удирдлагаар хангах;

5.2.2 Агаарын цэргийн захиргааны удирдлагаар хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн тухай ЗХЖШ-ын удирдлагыг мэдээллээр хангах;

5.2.3 Агаарын цэргийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

5.2.4 Агаарын цэргийг ашиглах, оперативын дэлгэн байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

5.2.5 Агаарын цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх баримт бичгийг боловсруулах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

5.2.6 Агаарын цэрэг /харьяа анги, салбар/-ийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

5.2.7 Агаарын цэргийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх;

5.2.8 Агаарын цэргийн командлал болон харьяа анги, салбаруудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бэхжүүлэх;

5.2.9 цэргийн сургалт бэлтгэлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих;

5.2.10 Агаарын цэргийн офицер, ахлагчийн албан тушаалын шалгуур үзүүлэлтийг анги, салбарт мөрдүүлэх, хяналт тавих;

5.2.11 Агаарын цэргийн анги, салбарын бүтэц орон тооны саналыг боловсруулж, цэргийн мэргэжлийн дээд байгууллагаар шийдвэрлүүлэх;

5.2.12 Агаарын цэргийн офицер, ахлагч нарын үйл ажиллагаа, мэргэжлийн ур чадварын түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах;

5.2.13 Агаарын цэрэг оролцсон нэгдсэн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

5.2.14 Агаарын цэргийн бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах ажлыг эрх хэмжээнийхээ хүрээнд зохион байгуулах;

5.2.15 Агаарын цэргийн зэвсэглэл, цэргийн техник, бусад материал хэрэгслээх хангах асуудлаар санал боловсруулж Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагад хүргүүлэх;

5.2.16 Агаарын цэргийн хэмжээнд төрийн болон албаны нууц хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах

5.3 Агаарын цэргийн командлагч нь байлдааны бэлэн байдал командлалд тавигдсан үүргийн хэрэгжилт, цэргийн аюулгүй байдал, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, цэргийн албаны асуудлаар ЗХЖШ-ын даргын өмнө хариуцлага хүлээнэ.

5.4 Агаарын цэргийн штабын дарга нь Агаарын цэргийн командлагчид захирагдах бөгөөд тайван цагт дараах үүргийг хэрэгжүүлнэ.

5.4.1 Цэргийг ашиглах үзэл баримтлал, төлөвлөгөө, дүрэм, журам, зааврын төсөл, байлдааны хариуцлагын бүс, чиглэл, үүргийг тогтоох саналыг боловсруулах ажлыг удирдлагаар хангах;

5.4.2 Цэргийн анги, салбарын байдал, бүрэлдэхүүн, хүч хэрэгсэл, үүрэг гүйцэтгэх боломжийг тогтоох;

5.4.3 Агаарын цэрэг, харъяа анги, салбарын байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө боловсруулах, тодотгох ажлыг удирдлагаар хангах;

5.4.4 Агаарын цэргийн бэлэн байдлыг хангах, анги, салбарын үндсэн болон тайван цагийн үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

5.4.5 Агаарын цэргийн удирдлагын бэлэн байдлыг хангах, харъяа ангиудын штабын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

5.4.6 Командлалын жил, улирал, сарын ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, төрөл мэргэжлийн цэргийн дарга нарын ажиллагааг удирдан зохицуулах;

5.4.7 Агаарын цэргийн Байлдааны тугийн хадгалалт, хамгаалалтын байдалд сар бүр үзлэг явуулж, тэмдэглэл хөтлөх, туг залах, оруулах, байрлуулах ажиллагааг зохион байгуулах;

5.4.8 Цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах ажиллагааг удирдлагаар хангах;

5.4.9 Командлалын бие бүрэлдэхүүний сургалтыг удирдах, ангийн штабын бэлтгэлийг удирдан чиглүүлэх;

5.4.10 Цэргийн судалгааны ажил зохион байгуулах;

5.4.11 ЗХЖШ штабын даргын болон командлагчийн тушаал, захирамж, үүргийг нийт бүрэлдэхүүнд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах;

5.4.12 Дотоод алба, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулж, сар бүр дүнг гаргах;

5.4.13 Албандаа идэвх зүтгэл гаргаж, гавъяа байгуулсан, санаачилгатай ажилласан, цэргийн алба хаагчийг шагнах, шагнуулахаар уламжлах;

5.4.14 Цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.4.15 Цэргийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, зааврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

5.4.16 Иргэд, бие бүрэлдэхүүний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх буюу ахлах даргад уламжлах;

5.4.17 Улсын хил хамгаалалт, улсын онц чухал объектыг хамгаалах, гамшгийн үед дэмжлэг үзүүлэх дэмжлэг үзүүлэх цэргийн анги, салбарын үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах;

5.4.18 Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлыг хуулийн дагуу хэрэгжүүлэх;

5.4.19 Анги, салбарын үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинд хяналт, шалгалт явуулж, үнэлэлт дүгнэлт өгөх.

5.5 Агаарын цэргийн тэргүүн ахлагч нь тайван цагт дараах үүргийг хэрэгжүүлнэ.

5.5.1 Зэвсэгт хүчний ахлагчийн албыг хөгжүүлэх, боловсронгуй болгох, ахлагч нарын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлого боловсруулахад ороцох;

5.5.2 Агаарын цэргийн анги, салбарт ажиллаж буй ахлагч нарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бодлогын асуудлыг тодорхойлох;

5.5.3 Агаарын цэргийн командлагчийг ахлагч нарын сургалт бэлтгэл, мэргэжлийн ур чадвар, сахилга, дэг журам, ёс зүй, нийгмийн асуудлаар үнэн бодит мэдээллээр хангах;

5.5.4 Агаарын цэргийн анги, салбарын удирдах албан тушаалын ахлагч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

5.5.5 Агаарын цэргийн анги, салбарын ахлагч нартай явуулж байгаа сургалтын үр дүнд дүгнэлт хийж, түүнийг сайжруулах арга замын талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

5.5.6 Ахлагч нарын нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах;

5.6. Командлалын бусад албан тушаалтны гүйцэтгэх үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгаж мөрдөн ажиллана.

Зургаа. Цэргийн мэргэжлийн дээд удирдлага, командлал болон бусад байгууллагуудтай харилцах

6.1. Командлагч нь цэргийн хэмжээнд явагдаж байгаа үйл ажиллагаа, үр дүнгийн талаар ЗХЖШ-ын удирдлагад тогтмол мэдээлнэ.

6.2. Командлал нь хугацаат мэдээний табелийн дагуу гаргаж өгөх мэдээ, тайлан, цаг үеийн асуудлаар гаргаж өгөхийг хүссэн мэдээлийг үнэн зөв гаргаж өгнө.

6.3. Төрөл мэргэжлийн цэргийн дарга нь өөрийн хариуцсан асуудлаар ЗХЖШ-ын бүтцийн нэгжийг үнэн бодит мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.

6.4. Командлал нь харъяа ангиудын үйл ажиллагааны тайлан, хугацаат мэдээ, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь хүлээн авч нэгтгэн дүгнэлт гаргаж, ЗХЖШ-ын холбогдох бүтцийн нэгжид хүргүүлнэ.

6.5. Командлал нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд холбогдох цэргийн байгууллагатай харилцаж болно.

6.6. Командлал нь цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагатай харилцан ажиллах төлөвлөгөөг тогтоосон хугацаанд тодотгож, хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.

6.7. Харилцан ажиллагааны төлөвлөгөөг тодотгох бүрт нотломж үйлдэж баталгаажуулна.

6.8. Командлал нь цэргийн болон бусад байгууллагуудтай харилцахдаа зөвхөн тогтоосон журмын дагуу албан бичгээр харьцана.

6.9. Командлал нь ЗХЖШ-ын даргын зөвшөөрлийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажил үүрэг гүйцэтгэж болно.

6.10. Командлал нь бусад байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, туршлага судлах, харилцан мэдээлэл солилцох, арга хэмжээг зохион байгуулж болно.

Долоо. Командлалын үйл ажиллагааны санхүүжилт

7.1. Командлалын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлнэ.

Найм. Дүрмийн хэрэгжилт, түүнд тавих хяналт, хариуцлага

8.1. Дүрмийг хэрэгжүүлэх ажлыг Агаарын цэргийн командлагч, штабын дарга хариуцаж зохион байгуулна.

8.2. Дүрмийн хэрэгжилтэнд ЗХЖШ-ын орлогч дарга болон Зэвсэгт хүчний Ерөнхий хянан шалгагч хяналт тавина

8.3. Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг командлалын зөвлөлийн хэлэлцүүлж, ЗХЖШ-ын даргын тушаалаар баталгаажуулна.

8.4. Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд цэргийн дүрэм бусад хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ